

## ЦАХИРЫН БИЧЭЭС

Ц.Баттулга\*

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын товөөс баруунш 20 орчим км-т, Тэсийн голын өргөн хөндийн хойт тал, Хул Азаргын нурууны зүүн бэл хормойг даган үргэлжлэх цагаан саарал чулуун тогтоц бүхий толгодыг ерөнхийд нь Цахирт гэх бөгөөд рашаант, баруун, зүүн, дунд Цахир гэж тус тус нэрлэнэ.

Галт уулын лав шавар, үнс, хайлмаг, хайрга чулуу холилдсон өвөрмөц тогтоц бүхий цагаан саарал, саарал, үнсэн хөх өнгийн шаварлаг зөөлөн чулуутай эл толгодын хаднаа сүг зураг, тамга тэмдэг түүгээр ч үл барам руни бичгийн дурсгал ч буйг 1981 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Увс, Хөвсгөл аймгийн нутаг дахь Чандманий соёлын дурсгал судлах шинжилгээний анги илрүүлжээ.

Руни бичгийн тухайд уг хээрийн шинжилгээний ангийн тайланд "...Хамгийн баруун талд Цахирын рашааны зүүн талын хэсэг хадны урд зүг харж тогтсон нэгэн ханан хаданд олон тооны хүн амьтны дүрс, тамга тэмдэг сийлсний дунд хоёр хэсэг газар 3 мөр руни бичиг хонхойлгон цохижээ. Нэг мөр нь 15 үсэг зурлага, хоёр дахь нь 3 зурлага, гурав дахь нь 9 зурлага үсгээс бүрдэж байна"<sup>1</sup> гэж тэмдэглэсэн байна.

Увс, Хөвсгөл аймгийн нутаг дахь Чандманий соёлын дурсгал судлах шинжилгээний ангийг удирдаж ажилласан ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Цэвээндорж уг бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор 1994 онд "Түүхийн судлал" сэтгүүлд мэдээ нийтлүүлжээ<sup>2</sup>.

Доктор Л.Болд 1990 онд хэвлүүлсэн "БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс" хэмээх номдоо "Цахирын түрэг бичээс" нэртэйгээр оруулан бүртгэж түрэг судлаач нарт дахин толилуулжээ. Тэрбээр "...энэ удаад уул бичээсийн талаар урьдчилсан таамаглал төдий зүйлийг ч эрхэм уншигч Та бүгдэд хэлж чадахгүй байна. Гэвч манай түрэг судлаачид дахин уул бичээсийг нарийвчлан хуулж, түүний "нууц"-ыг тайлан Та бүхэнтэйгээ саналаа хуваалцах цаг төдий л хол биш болжээ"<sup>3</sup> хэмээн тэмдэглэсэн байна.

Д.Цэвээндорж гуай хээрийн шинжилгээний ангийн тайлан болоод уг бичээсийн тухай мэдээндээ бичээсийн гар хуулбар, гэрэл зураг огт хавсаргаж дагалдуулаагүй нь ихээхэн сонирхолтой.

\* МУИС, ГХСС, Түрэг судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

<sup>1</sup> Д.Цэвээндорж, 1981 онд Увс, Хөвсгөл аймгийн нутаг дахь Чандманий соёлын дурсгал судлах шинжилгээний ангийн тайлан, 1982, Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

<sup>2</sup> Д.Цэвээндорж, Новые памятники Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур цогро, -Studia Historica, Tom. XVII, fasc.1-13; Улаанбаатар, 1984, 124-126 дугаар тал.

<sup>3</sup> Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 138 дугаар тал.

Тиймээс ч уг бичээсийг уншиж судлах боломж түрэг судлаач нарт олдоогүй юм. Нөгөө талаар гар хуулбар, гэрэл зураг зэрэг бодит эх хэрэглэгдэхүүн, баримт байхгүй байсан нь түрэг судлаачид бичээс байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэжээ.

Бид бүтээлдээ “Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал”-д хамруула оруулахдаа 1997 оны зун Тэсийн гэрэлт хөшөөний суурийг дахин үзэх далимд Цахирын түрэг бичээсийг доктор А.Очирын хамт одрийн хугас эрсэн боловч тухайгаа тодорхой бичсэн билээ<sup>4</sup>.

1997 оны зун, цаг хугацааны давчууд бичээсийг олж эс чадсан ч хожмын нэг өдөр дахин ирж олж судлах чин хүсэл өвөрлөн буцсан билээ.

Арван жилийн өмнөх, тэрхүү хүслээ биелүүлэхээр 2008 оны 7-р сарын 4-өөс 12 хүртэл Цахирын “хад чулуу бүрийг харж, зураг, дүрс, тамга бүрийг хуулан буулгаж, хожмын өдөр судлаач нарт хэрэг болох буй за хэмээн санаж цахим бичвэрт шингэж, гэрэл зурагт буулган” нийтдээ найман өдөр уйгагүй ажилласан юм.

Тайлан, мэдээ зэрэгт зааж тэмдэглэсэн газарт үнэхээр байхгүй нь хоёр удаагийн судалгаагаар тодорхой болсон ч арван хэдэн километр үргэлжлэх уул, толгодын хормой, бэл, энгэр, толгойн хаа нэгэнтээ хад чулуунаа магад буй хэмээн бат итгэж өглөөний улаан нартай уралдан эрэлд гарч гал үдэд амарч их үдээс шар нарны шингэх тус тасартал бэдэрсэн нь мунхаг би бээр нарны тусгалаас шалтгаалан үзэлгүй өнгөрүүзэй хэмээснийх билээ.

Д.Цэвээндорж гуай бүтээлдээ хэвлүүлсэн Цахирын хадны зураг бүрийг бараг эх зурагтай нь тулган үзэж чадсан ч 15, 3, 9 үсэг тэмдэгт бүхий 3 мөр руни бичээсийг огт олсонгүй.

Арав, хорин километр үргэлжлэх, хэдэн мянган зураг бүхий уул, нурууны хад чулуунаас хялгас мэт, тун нарийн зурчиж бичсэн, цор гагц мөр руни бичээсийг хэд хэдэн удаа олж асан урьдын явдал зөлд урамшин эрэмшиж хонхойлгон цохисон басчиг цөөнгүй үсэг тэмдэгт бүхий энэ бичээсийг олж чадна хэмээн бодсон минь ийнхүү талаар болсон билээ. Бид олоогүй болохоос бичээс байхыг үгүйсгэх аргагүй.

Юутай ч хоёр өөр газраас тус бүр нэг мөр бичээс илрүүлсэн билээ.

#### **Хадны зураг**

Цахирын хадны зургийг Д.Цэвээндорж гуай судалж “Монголын эртний урлагийн түүх” хэмээх бүтээлийнхээ нэг гол эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан байна. Тэрбээр Цахирын хадны зургийг он цагийн хувьд хүрэл ба төмөр зэвсгийн үед, зурсан аргынх нь хувьд хадны сийлмэл зургийн төрөлд багтана хэмээн үзжээ<sup>5</sup>.

#### **Тамга тэмдэг**

Цахирын хаднаа “... нийтдээ 73 янзын тамга байна”<sup>6</sup> гэж өгүүлсэн байдаг. Бидний судалгаанаас үзэхэд Цахирын хаднаа буй тамганы төрөл төдий л олон биш харин нэг тамгын хувилбар тамга олон байсныг тэмдэглэе.

Цахирын хадны зураг болоод тамга тэмдгийг судалж тухайлсан өгүүлэл нийтлүүдэх тул товч өгүүлэв.

#### **Бичээс**

Хөвсгөл аймгийн нутагт буй руни бичгийн дурсгалыг дурдвал,

<sup>4</sup> Ц.Багтулга, Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -Corpus Scriptorum, Том.1, Улаанбаатар, 2005, 107 дугаар тал.

<sup>5</sup> Д.Цэвээндорж, Монголын эртний урлагийн түүх, Улаанбаатар, 1999, 71-75 дугаар тал.

<sup>6</sup> Д.Цэвээндорж, Монголын эртний урлагийн түүх, Улаанбаатар, 1999, 73 дугаар тал.

1. Цагаан уул сумын Өвөр булгийн хөх толгой гэдэг газраас 1976 онд илрүүлсэн Тэсийн гэрэлт хөшөө,

2. 1986 онд судалсан, Ринчинлхүмбэ сумын нутаг Шишгэд голд цутгах Харанга ой голын Орюк хадны бичээс болно.

Руни болоод бусад бичгийн дурсгал тун цөөхөн байгаа нь Хөвсгөл аймгийн нутаг дахь түүх, археологийн дурсгалыг судлах хээрийн судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүйтэй холбоотой. Тиймээс аймгийн бүх нутаг дэвсгэрийг хамарсан хайгуул, судалгаа хийх зайлшгүй шаардлагатай бөгөөд судалгааны ажлын хүрээнд олон арван дурсгал шинээр илрүүлэх нь лавтай.

Тус аймгийн нутагт байдаг хэмээн тэмдэглэсэн руни бичгийн гурав дахь дурсгал бол Цахирын бичээс билээ. Харамсалтай нь судлаачдын өмнө мэдээлсэн Цахирын бичээсийг олоогүй ч, шинээр илрүүлсэн бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор толилуулж байна.

Руни бичгийн сонгодог дурсгал олонтой, бага бичээс гэхэд л хэд хэдэн мөр төдийгүй үсэг тэмдэгтүүд нь ч ихэвчлэн тодорхой байдаг тул ялангуяа Кавказ, Мажарын руни лүгээ адил ганц нэг мөр, өвөрмөц үсэг тэмдэгт бүхий бичээсийг “үл ойшоон, эс тоож” өдий хүрсэн билээ. Энэ мэт бичээс Монгол нутагт цөөнгүй буй.

Тэдгээр бичээсийн тухай мэдээлэх, бүртгэл гаргах, тайлж унших нь үсэг бичиг, тамга судлалд төдийгүй Төв Азийн нүүдэлчдийн хэл, соёл, түүхийн судлалд чухал ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болох юм.

Цахирын хоёрдугаар бичээсийг тамга гэхэд бэрхтэй, бас руни бичиг хэмээн үзэж уншихад төвөгтэй ч ийм нэгэн зүйл дурсгалуудыг судалгааны эргэлтэнд оруулах ажлын эхлэл болгож “Цахирын хоёрдугаар бичээс”-ийг мөн толилуулж байгаа болно.

#### Цахирын нэгдүгээр бичээс

Рашаант Цахирын зүүнтэйд, Болдог толгойн ар шилээр дайрч гарах машины замын зүүн галд том хавтгай саарал чулуун дээр нэг мөр руни бичээс байна.

Барсгар гадаргатай чулуун дээр өнгөц, үл ялиг хонхойлгон цохиж бичсэн тул дардас авах боломжгүй. Бичээс тодорхой, сайн харагдавч гэрэл зурагт төдий л сайн гарахгүй байсныг тэмдэглэе.

Бичиж бүрэн дуусгаагүй орхисон эл бичээс найман үсэгт тэмдэгтээс бүтэх бөгөөд гурав дахь тэмдэгт нэлээд эргэлзээтэй байна.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ᠮᠠᠨᠢᠨᠨᠨ

Үсгийн галиг:

Y Q Q s ᠑ i Q : ь

Үгийн галиг:

yaqqa si᠑iqa: ...

Орчуулга:

Захад, хил хязгаарт...

Тайлбар:

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад оршихын тийн ялгалын ᠮ q хөхцөл нь ямагт ᠮ хэлбэрээр бичигддэг тул зөвбичихзүйн үүднээс авч үзвэл yaqqa si᠑iqa гэж унших боломжгүй юм. Гэхдээ руни бичгийн бага дурсгалуудад зөвбичихзүйг

тэр бүр баримталдаггүй, түүгээр ч үл барам үсэг тэмдэгтийг буруу харуулах, хатуу, зөөлөн гийгүүлэгч хольж бичих тохиолдол цөөнгүй.

Тиймээс бид  $yaq+qa$ ,  $si\dot{c}i+qa$  гэж унших саналтай байна.  $si\dot{c}i$  нь хятад хэлний 西 至  $sm\ zhm$  буюу хил хязгаар<sup>7</sup> хэмээх үг ажээ.

### Цахирын хоёрдугаар бичээс

Тэсийн голын хөндий рүү түрж тогтсон, дунд Цахирын хаднаа эл бичээс буй. Долоон тэмдэгтээс бүтэх эл дурсгалыг руни бичээс хэмээн үзвэл доорхи мэт унших болох юм.

Бичээсийн эхийн сийрүүлэг:

Y 1411↓h

Үсгийн галиг:

t oQ s s R η l

Үгийн галиг:

toqsis aran[aran ~eren~ erän]? il

Орчуулга:

Үгээгүй ард, улс

Тайлбар:

toqsis < toq + sis

toq – язгуур нь 1. цатгалан, тарган, дүүрэн, баян 2. аз жаргал, хувь тавилан гэсэн утгатай билээ. Эл язгуур үгнээ үгүйсгэх утга бүхий –41 siz нөхцлийг залгахдаа –ll sis нь хэлбэрээр бичсэн байж болох юм.

Көлтигин, Билгэ хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс болон түрэг хэлний сурвалжуудад цэргүүд, эрчүүд, хүмүүс, ард, иргэд гэсэн утгатай “eren~ дгд, aran” гэх үгс цөөнгүй тохиолдоно. Divanü Lygat-it-Türk толь бичигт er-ийн олон тоо eren<sup>8</sup> болно хэмээн тайлбарлажээ.

### Summary

It is informed that Runic inscription was found in Tsahir, Tsetserleg soum of Huvsgul province in 1981. Author did researches in 1997 and 2008 to find the inscription. Three lines of inscription which known previously had not been found yet, but two Runic inscriptions with each line had been discovered. They are as follows:

#### First inscription:

Origin of the inscription: 𐰃:𐰆𐰇𐰈𐰉𐰊

Transliteration: Y Q Q s ė i Q : ü

Transcription: yaqqa siċiqa: ...

Translation: Edge, border

#### Second inscription:

<sup>7</sup> Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 502.

<sup>8</sup> Divanü Lygat-it-Türk dizini, Endeks, zeviren Besim Atalay, 4.Baskı, cilt IV, Ankara, 1999, s.187.

Origin of the inscription: Y 44||↓k

Transliteration: t oQ s s R η l

Transcription: toqsis aran[aran ~eren~ erān]? il

Translation: Poor people, nation (state)

### Номзүй

Баттулга Ц. (2005) Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -Corpus Scriptorum, Tom.I, Улаанбаатар.

Болд Л. (1990) БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар.

Древнетюркский словарь, (1969) Ленинград.

Divanь Лыгат-ит-Түрк dizini, Endeks, zeviren Besim Atalay, 4.Baskı, (1999) cilt IV, Ankara.

Divanь Лыгат-ит-Түрк dizini, Endeks, zeviren Besim Atalay, 4.Baskı, (1999) cilt IV, Ankara.

Цэвээндорж Д. 1981 онд Увс, Хөвсгөл аймгийн нутаг дахь Чандманий соёлын дурсгал судлах шинжилгээний ангийн тайлан, 1982, Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Цэвээндорж Д. (1999) Монголын эртний урлагийн түүх, Улаанбаатар.


Цэвээндорж Д. (1984) Новые памятники Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур цорго, -Studia Historica, Tom. XVII, fasc.1-13, Улаанбаатар.



Рашаант цахир



Цахирын I бичээс



Цахирын II бичээс

Цахирын хадны зураг, тамга тэмдгээс

